



**ОРХОН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2017 оны 09 сарын 05 өдөр

Дугаар А/515

Эрдэнэт

Хөрөнгө гаргах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5./а/, 29.2 дахь заалт, Биеийн тамир, спортын тухай хуулийн 10.1.2, 10.1.7 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн ээлжит 4 дүгээр хуралдааны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2017 оны 09 дүгээр сарын 07-10-ны өдрүүдэд Өвөрхангай аймгийн Арвайхээр хотноо зохион байгуулагдах Монголын мастеруудын 3-р наадамд оролцох баг тамирчдад 1000000 төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дэмжлэгт шаардагдах 1000000 / Нэг сая / төгрөгийг Засаг даргын нөөц сан хуваарилагдаагүй бусад зардлын "Соёл, спорт, хүүхэд залуучууд, олон нийтийн арга хэмжээг жилийн туршид зохион байгуулах арга хэмжээний зардал"-аас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.БАТЛУТ